



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/696

Хэрлэн сум

Аймгийн 2023 онд онцлох амжилт гаргасан байгууллага, аж ахуй нэгж, залуучуудыг шалгаруулах арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 онд онцлох амжилт гаргасан албан байгууллага, аж ахуй нэгж, залуучуудыг шалгаруулах үйл ажиллагааг 2023 оны 12 дугаар сарын 28-ний өдөр Чингис хотод зохион байгуулахад зориулж 7,280,000 (долоон сая хоёр зуун наян мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 19-ны  
А/646 дугаар захирамжийн хавсралт

ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Зочдын урилга хэвлүүлэх	250	8,500	2,125,000
2	Угталтын арга хэмжээний хувцас түрээс	4	50,000	200,000
3	Сценарын шүлэг бичүүлэх	1	300,000	300,000
4	Угталтын үүдний баннер хийх	1	300,000	300,000
5	Өвлийн өвгөний ажлын хөлс	1 хүн	300,000	300,000
6	Тайзны салют	9ш	50000	450,000
7	Зохион байгуулах газрын заалны түрээс	1	2,000,000	2,000,000
8	360 камер	1ш	1,500,000	1,500,000
9	Лед, гэрэлтүүлэг зөөх шатахуун	25л	4200	105,000
<b>Нийт үнэ</b>				<b>7,280,000</b>